



Бадрах Энержи ХХК

© Зөвч-Овоо үйлдвэрлэлийн туршилт дээр ажиллаж байгаа хамт олон




Бадрах Энержи ХХК нь Дорноговь аймгийн нутагт нөөцөөрөө дэлхийд дээгүүрт орох Зөвч-Овоо ураны ордын нарийвчилсан судалгааг хийж буй хариуцлагатай уул уурхайн компани юм. Монгол Улсын ураны салбар дахь төслүүдээс хамгийн ахисан шатанд үйл ажиллагаагаа явуулж байна.

Бадрах Энержи ХХК олон улсад шалгарсан туршлага бүхий стандартыг мөрдөж, байгаль орчин хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн салбарт шилдэг үзүүлэлттэй ажиллаж буйдаа бахархаж байна.

Онцлох үйл явдал:	
2013:	Зөвч-Овоо ордын нөөцийг бүртгүүлсэн
2013:	Хувьцаа эзэмшигчдийн гэрээ байгуулсан
2015:	Зөвч-Овоо төслийн ТЭЗҮ батлагдсан
2016:	Ашиглалтын 3 тусгай зөвшөөрөл олгогдсон
2017:	Мон-Атом ХХК хувьцаа эзэмшигч болов (34%)
2018:	АРЕВА Майнс ХХК нэр Бадрах Энержи ХХК болсон
2018:	Үйлдвэрлэлийн туршилтын барилгын ажлыг гүйцэтгэсэн

Бадрах Энержи ХХК-ийн хувьцаа эзэмшигчид



2013 оны 10 дугаар сарын Хувьцаа эзэмшигчдийн гэрээний дагуу Бадрах Энержи ХХК-ийн:

- 66 хувийг АРЕВА Монгол ХХК,
- 34 хувийг Төрийн өмчит Мон-Атом ХХК тус тус эзэмшиж байна.

* АРЕВА Монгол ХХК - 66 хувь нь Орано групп, 34 хувь нь Мицубиши Корпорацийн эзэмшлийн компани юм.

Ураны нөөц баялаг

Бадрах Энержи ХХК Зөөвч-Овоо, Дулаан Уул ба Өмнөд ураны ордуудад ашиглалтын гурван тусгай зөвшөөрөлтэй. Ордуудын бүртгэгдсэн ураны нөөц нь Монгол Улсын албан ёсны ураны нөөцийн 44 хувь юм.



Зөөвч-Овоо Үйлдвэрлэлийн туршилт

Бадрах Энержи ХХК Зөөвч-Овоо орд дээр нарийвчилсан судалгаа, тухайлбал нарийвчилсан ТЭЗҮ, Үйлдвэрлэлийн туршилтын ажил хийж гүйцэтгэж байна.

Үйлдвэрлэлийн туршилтын үр дүнгээр ТЭЗҮ-н техник, эдийн засгийн үзүүлэлтийг баталгаажуулна.

Монгол Улсын Байгаль Орчин, Ногоон Хөгжил, Аялал Жуулчлалын Яам Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг 2016 оны 3 дугаар сард баталсан.

2 жил үргэлжлэх үйлдвэрлэлийн туршилт ураны уурхайн бүх үе шат, тухайлбал уран олборлолтоос, ураны бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспортыг хамарна.

Уг үйлдвэрлэлийн туршилт нь уурхайг ашиглахад сонгоод байгаа газрын дор уусган олборлох арга нь байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл бага болохыг батлах өгөгдөл, мэдээллээр хангана. Үйлдвэрлэлийн туршилтын хяналтанд нутгийн иргэдийг оролцуулна.

Бадрах Энержи ХХК нь нутгийн иргэдийг ажлын байраар хангахад онцгой анхааран ажилладаг ба Үйлдвэрлэлийн туршилтын ажилчдын дийлэнхийг Улаанбадрах сум, Зүүнбаян багаас аваад байна.

Газрын дор уусган олборлох арга гэж чухам ямар арга технологи вэ?

- ISR буюу газрын дор уусган олборлох аргаар Зөөвч-Овоо ураны ордыг олборлоход ашиглахаар төлөвлөж байна.
- Тус арга нь уламжлалт уурхайлах арга болох ил болон гүнийн уурхайгаар олборлох боломжгүй элсэн чулуун дахь ураны ордыг олборлоход ашигладаг арга юм.
- Өнөөдөр газрын дор уусган олборлох арга нь уран олборлоход хамгийн өргөн ашиглагдаж буй арга болоод байна. Дэлхийд олборлож байгаа ураны ойролцоогоор 48 хувийг тус аргаар олборлож байна.
- Газрын дор уусган олборлох аргаар бусад метал, тухайлбал зэс олборлодог.

Компанийн нийгмийн хариуцлага

Бадрах Энержи ХХК төслийн оролцогч талуудтай тогтмол уулзалт, яриа хэлэлцээг хөгжүүлж ирлээ.

- Монгол Улсын Ашигт малтмал, газрын тосны газартай Орд ашиглах гэрээг 2016 онд,
- Улаанбадрах сум, Зүүнбаян багтай Хамтын ажиллагааны гэрээг 2018 онд байгуулсан

Тус гэрээгээр компаниас нийгмийн хөгжлийн төслүүдэд дараах чиглэлээр оруулах хувь хандивыг баталгаажуулав. Үүнд: **усны хүртээмж, хүний эрүүл мэнд, боловсрол, соёл, эдийн засгийн хөгжил, малын эрүүл мэнд, эрчим хүчний хүртээмж.**

- Төслийн талбайн хөрш малчин айл өрхийн төлөөлөлтэй Орон нутгийн хамтын ажиллагааны зөвлөлийн хурлаар тогтмол уулзаж байна..



Хамтын оролцоотой байгаль орчны хяналтын хөтөлбөрийг орон нутгийн захиргаа, иргэдийн төлөөллийн оролцоотой 2013 оноос хэрэгжүүлж байна.

Бадрах Энержи ХХК-ийн нутгийн иргэдийг дэмжих, хөгжүүлэхэд чиглэсэн төслийн жишээ

- Улаанбадрах сум, Зүүнбаян багийн малчдын хамтын санаачлагыг дэмжих, малын эрүүл мэндийн төсөл (2014-2017)
- Орлого бий болгох, ажил эрхлэх зэрэгт 100 өрхөд туслах FXB төсөл (2015-2018 онд хэрэгжсэн, төслийн хугацаа ахин 3 жилээр сунгагдсан)
- Сайншандын нэгдсэн эмнэлэгт эмнэлгийн тоног төхөөрөмж
- Улаанбадрах сумын Наадмын стадион
- Дээд боловсрол олгох оюутны тэтгэлгийн хөтөлбөр зэрэг багтана.



Холбоо: byambadolgor.lvsanjamts@orano.group

Бадрах Энержи ХХК
Ай Си Си Цамхаг, 3-р давхар,
Жамъян гүний гудамж 9
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо

Улаанбаатар, Монгол Улс
Phone: +967 11 7011 0475 (103)

